



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/52

Мандлговь

Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөнөөс орон
нутгийн төсөвт төвлөрсөн мөнгийг зарцуулах тухай

Монгол Улсын "Цэргийн албаны тухай хууль"-ийн 7 дугаар бүлгийн 31 дүгээр зүйлийн 8, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын хавсралт "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын 4.1 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар баталсан журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг дарын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03 дугаар хурал-ын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс орон нутгийн төсөвт төвлөрсөн хөрөнгийг хавсралтын дагуу зарцуулахыг аймгийн Цэргийн штабын даргад үүрэг болгосугай.

Хоёр. Шаардагдах 15.000.000 /арван таван сая/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/-д, нягтлан бодогч /Д.Нандинцэцэг/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200154

Аймаг, нийслэлийн Засаг дарга 2018 оны 02 дугаар сар 07 ны өдрийн 02 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

2018 онд Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөнөөс орон нутгийн төвлөрсөн мөнгөнийг зарцуулах төсөв

д/д	Зарцуулалт	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Огноо	Зарцуулалт
1	4.1.1 Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс болон батлан хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	2.000.000	III, X	Нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар цэрэг эх орны сэдэвт урлаг соёлын арга хэмжээг зохион явуулах 1.000.000, III сард Хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар цэрэг эх орны сэдэвт урлаг соёлын арга хэмжээг зохион явуулах 1.000.000, X сард
2	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах, дайчилгааны даалгаврын тодотгол хийх, сургалтын материаллаг баазыг бүрдүүлэх	3.500.000	II, III	Дайчилгааны даалгаврыг тодотгох ЗХ-ний 167 анги, аймгийн сумдтай /600.000, III сард/ Цэргийн Төв эмнэлэг, аймгийн сумдтай /400.000, III сард/ Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний 30 хүний сургалт явуулах материаллаг баазыг бэлдэх. Үүнд: гал тогооны табель хэрэгсэл, ор хөнжил, гудас, гал тогооны майхан худалдан авах /2.500.000, II, III сард/
3	Аймаг, нийслэлийн батлан хамгаалах газар, сум, дүүргийн батлан хамгаалах товчооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	1.500.000	V, IX	Сумдад батлан хамгаалах товчооны байрыг тохижуулах, шаардагдах материал хэрэгсэл авах 1.000.000, V сард Аймгийн батлан хамгаалах газрын удирдах байрыг тохижуулах, материал хэрэгслээр хангах. 500.000, IX сард

4	Цэргийн штаб үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх	6.000.000	Жил	Цэргийн штабын тээвэр шатхууны зардалд 2.000.000, жилийн хэрэгцээнд
				Ажлын байрны тохижилт, тоног төхөөрөмж шинэчилэх 2.000.000.
			III	Зэвсэгт хүчний 97 жилийн ойн, Баруун хилийн тулгарах байлдааны 70 жилийн арга хэмжээг зохион байгуулж явуулах 2.000.000
5	4.1.9. Батлан хамгаалах үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд идэвхи санаачлагатай ажилласан иргэн, албан тушаалтныг урамшуулах	2.000.000	Жил	2.000.000
Нийт		15.000.000 төгрөг		